



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04-р сарын 18-ны өдөр

Дугаар ХЭ-25/01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 13:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Хурлыг Булигаар ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Баттүшиг даргалж, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүд Т.Болд, Ч.Нямдорж, Ж.Эрдэнэбат, Сөрөлт дөл аудит ХХК-ийн төлөөлөгч нар оролцов.

Хурлын дарга Б.Баттүшиг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд Тооллогын комиссоос хурлын ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Г.Анужин: Булигаар ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 17-ний өдрөөр тогтоосныг дурдъя.

Бүртгэлийн өдрөөр Булигаар ХК-ийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны тоо 400,212,000 ширхэг байснаас өнөөдрийн хурал биечлэн оролцох арга хэлбэрээр нийт 352,713,190 ширхэг саналын эрхтэй 10 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.13** хувь болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Баттүшиг: Хурлын дэгийг товч танилцуулахад:

- Хэлэлцэх асуудлын дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ.
- Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт явагдана.
- Санал хураалт явагдана.
- Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулна.
- Хурлаас гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

Хурлаар хэлэлцэх, танилцуулах асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн танилцуулж, 3-н асуудал дээр санал авч шийдвэр гаргах байгаа.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгийн тайланг болон Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулна.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулна.
3. 2024 оны ногдол ашгийн тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна.

4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
5. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах;
6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар мэдээллийг та бүхэнд хүргэж санал хураалтаар шийдвэр гарна.

ХЭЛЭЛЦЭХ, ТАНИЛЦУУЛАХ АСУУДЛУУД:

Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах.

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Өнөөдрийн хурлаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлуудын эхний асуудал бол Булигаар ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах юм. 2023 оны гүйцэтгэлтэй харьцуулсан гол үйл ажиллагааны үр дүнг дэлгэцэд харуулсан байгаа. Эдгээр 6 үзүүлэлтүүдийг бол харж байна. Борлуулалтын орлого бол 1 дүгээрт 8.6 тэрбум төгрөг болж өмнөх одоо тайлант үеэс 19.7%-аар өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Цэвэр ашиг 95.5 сая төгрөг байна. За энэ борлуулалтын орлогод эзлэх одоо дотоодын борлуулалт нь 7.4 тэрбум төгрөг болж одоо өмнөх оны мөн үеэс 27% өсөлттэй гарсан байна. Эсрэгээрээ гадаад борлуулалт бол 11%-ийн уналттай харагдаж байна. Одоо энд одоо голчилж нөлөөлж байгаа юм нь юу вэ гэхлээр манай компанийн хувьд ер нь Монголын арьс ширний салбарын хувьд гадаад борлуулалт хийдэг одоо үндсэн 3 орон байж байгаа БНХАУ, Турк улс, Итали улс байж байгаа. Тэгэхээр эдгээр орнуудад одоо гарч байгаа эдийн засгийн хямрал болон геополитикийн сөрөг үр дагаврууд нь бидний одоогийн гадаад борлуулалтад сөргөөр нөлөөлж байна. За мөн одоо БНТУ-д та бүхний мэдэж байгаа 2023 оны 5 дугаар сард болсон том газар хөдлөлт байгаа. Үүний уршгаар ханшийн их уналтад орж, инфляц өссөн БНТУ-ын эдийн засгийн салбар тэр дундаа арьс ширний салбар бол сайнгүй үзүүлэлттэй байна. За ингээд цааш үр үргэлжлүүлэх юм болбол бодын арьсны дундаж талбайн хэмжээ гэж байгаа. Бид нар бол үхрийн ширэн дээр голчилж ажиллаж байна. Үхрийн ширийг бол бид нар ширхгээр нь тоолж хүлээж аваад дм.кв-аар нь буцаад зах зээлд нийлүүлдэг учраас бид нарт бол энэ талбайн хэмжээ бол нэн чухал үзүүлэлт гэж ойлгож болно. Тэгэхээр бодын арьсны дундаж талбайн хэмжээ 223.6 дм.кв байна. Энэ нь бол түрүү оноосоо 22.5%-аар өссөн үзүүлэлт байна. За үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний одоо дундаж үнэ гэж бас байдаг. 471.4 төгрөгөөр 1 дм.кв-ыг дундаж үнээр нь зах зээлд борлуулж байна аа гэсэн үг. Энэ нь юуг илтгэж байна вэ гэхлээр бид нарын худалдаж авч байгаа түүхий эдүүд маань бүгд нэг төрлийн бүтээгдэхүүн болохгүй дотроо өөр өөр багц болж салдаг байж байгаа. Мянган ширхэг үхрийн шир аваад заавал мянгаар нь нэг төрлийн арьс хийхгүй ээ гэсэн үг. Заримаар нь илүү өндөр үнэтэй, өндөр өртөгтэй арьс хийнэ. Зарим нь арай боломжийн бөгөөд бага өртөгтэй арьс хийдэг. Ингээд эдгээрийг багцлаад дундаж үнэд байнгын бид нар анализ хийж дүгнэж явдаг байж байгаа 2024 оны хувьд бол 471.4 төгрөгтэй гарсан байна. За та бүхний бас мэдээлэл авсан байх 2025.01.01-ний өдрөөс компани борлуулах арьсанд үнийн бодлогод өөрчлөлт оруулаад, одоо мөрдөөд энэ шинэ үнийн бодлогоороо ажиллаад явж байгаа. За санхүүгийн үзүүлэлт нийт борлуулалтын орлого. Ингээд график дээрээс харах юм бол 2023 онд бид бүхэн 7.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж байсан бол 2024 онд 8.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Цэвэр ашиг 95.5 сая гэж

түрүүн хэлсэн. Нийт хөрөнгө 2024 оны байдлаар 32.5 тэрбум төгрөг, 2023 оны 33.9 тэрбум тэрбумаас буурсан нь элэгдлийн зардлыг одоо шингээж өгсөн байж байгаа. За нийт хөрөнгөд эзлэх одоо хамгийн голлох хөрөнгө нь мэдээж үндсэн хөрөнгө байна 17.3 тэрбум төгрөг, бэлэн мөнгө бараа материал 5 тэрбум төгрөг гэдэг маань одоо бид нарын эргэлт бас томорч байна сайжирч байна гэдгийг бас илтгэсэн үзүүлэлт байна. За үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн анхан шатны гэж байгаа юм. Манай арьс ширний үйлдвэрлэл үндсэндээ 3 шат дамжлага бүхий 3 цехүүдээс бүрддэг. Эхний цехэд бол бид нар химийн боловсруулалт хийж байна. Химийн боловсруулалт хийсэн арьсыг болбол нэг бол гаднын орнуудад экспортолж байна нэг бол дараа дараагийн шат дамжлагад нь бэлдээд явж байгаа. Бид нар 2024 онд анхан шатны үйлдвэрлэлд 95,350 ширхэг бодын арьс буюу одоо үхрийн ширийг анхан шатны үйлдвэрлэлд хийсэн байна. 267 мянган ширхэг богийн арьс буюу ямааны арьсыг анхан шатны үйлдвэрлэлд хийсэн байна. 2025 онд болбол бид нар богийн арьсны хийх тоо илүү багасгаж, бодын арьсны тоог өсгөх чиглэлд голчилж түлхүү ажиллаж байна. Яагаад вэ гэвэл түрүүн миний хэлсэн шалтгаантай холбоотой манай үйлдвэрээс гардаг экспортын гол бүтээгдэхүүн бол богийн арьс буюу ямааны арьс байж байгаа. Тэгэхээр экспортын ийм чиг хандлагыг урьдчилж таамаглаад 2025 онд бол бодын арьсан дээр түлхүү ажиллах төлөвлөгөөтэй байгаа. 2023 онд бидний үйлдвэрлэж, борлуулж байсан 1дм.кв арьсны дундаж үнэ 439.3 төгрөг байсан бол 2024 онд 471.4 төгрөг болж өссөн байна аа. Энэ нь бол бүтээгдэхүүний чанар өсөж байгаа гэж тайлбарлаж болно. Нөгөө талаасаа 13.5 сая дм.кв арьсыг 2023 онд үйлдвэрлэсэн бол 2024 онд 16.3 дм.кв арьсыг үйлдвэрлэсэн байна.

Тэгэхээр үйлдвэрлэлийн хүчин чадлыг илүү оновчтой үр ашигтай байдлаар ашиглаж одоо үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна. За үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоон үзүүлэлт ингээд сар сараараа бас харуулсан байгаа. Та бүхэн харж байвал Монгол арьсны дундаж дм.кв-ыг цэнхэр өнгөтэй графикийг харж болно. Нэг дм.кв-ын дундаж үнэ бол одоо энэ дээд талд байж байгаа. Энэ 517, 423 гээд эхэлж байгаа шар шугаман график байж байна. За энэ 3 ширхэг ногоон нь юу вэ гэхлээр бид нар 2024 оны одоо 1, 2, 3 дугаар сард гадаад орноос түүхий эд авч бас туршиж үзсэн байж байгаа. Зөвхөн Монгол түүхий эдээрээ ажиллаад зогсохгүй, Өмнөд Америкаас түүхий эд авчирч хийж үзсэн. Бас 2025 он гаргаад 1, 2 сард Орос улсаас түүхий эд авчирч одоо үйлдвэрлэлдээ нэвтрүүлж үзэж байгаа нь одоо дотоодын бүтээгдэхүүний чанарыг илүү сайжруулах. Энэ гутал үйлдвэрлэгч нарт одоо яг хэрэгцээтэй түүхий эдийг нь бэлтгэж, өгөх гэсэн бид нарын гол зорилгыг хангаад явж байгаа гэсэн үг. За гадаад борлуулалт бол түрүүн хэлсэнчлэн 2024 оны байдлаар бол 14%-ийг нь эзэлж байна. Нийт борлуулалтын дотоод борлуулалт бол 86%-ийг эзэлж байгаа. Энэ хувь цаашдаа ер нь улам жоохон салаад явах хандлагатай байгаа. Илүү дотоодынхоо зах зээлд төвлөрөөд ажиллаж байгаа импортыг орлох бүтээгдэхүүнийг бол одоо илүү ихээр түлхүү үйлдвэрлэнэ ээ гэсэн зорилготой ажиллаж байна. За хөрөнгө оруулалтын тухайд бид нар 2024 онд 653.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүний дийлэнх нь буюу 72.1%-ийг нь тоног төхөөрөмжид зориулсан байж байгаа. Тоног төхөөрөмжийн шинэчлэл, сайжралттай холбоотой тоног төхөөрөмжийн шинэчлэлд бол цаанаа ямар үр дагаврыг авчирч байна вэ гэхлээр бүтээмжийг нэмэгдүүлэх арьсны чанарыг сайжруулах гэсэн зорилготой. Дараах тоног төхөөрөмжүүдийг бол бид нар 2024 онд шинэчлээд одоо суурилуулчихсан байж байгаа. Нэг нь бол БНТУ-аас 4 давхарт манай Гүйцэтгэн

боловсруулах цехэд өнгө заслын будгийн цоо шинэ агрегат машиныг авчирч суурилуулсан. Одоо хуучин байгаа машин дээрээ нэмж, ийм орчин үеийн шинэ систем авч суурилуулсан гэсэн үг. Мөн Солонгос улсын энэ Ротопи брэндийн арьс шахах, арьсны чийгийг арьснаас гаргах илүүдэл усыг шахаж зайлуулдаг 90 мянган долларын өртөгтэй ийм цоо шинэ машин авчирч Химийн боловсруулах цехдээ суурилуулсан байж байгаа. 2024 оны онцлох үйл явдал Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Булигаар ХК-ийн үйл ажиллагаатай 2024.01.12-ны өдөр танилцсан байж байгаа. 2024 оны 3 сард бид нар Ази Номхон далайн одоо хамгийн том үзэсгэлэн Эй Пи Эл Эф гэж үзэсгэлэнд улсаа, салбараа төлөөлж амжилттай оролцоод ирсэн байна. Мөн компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг Хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх компаниудын засаглалыг нь үнэлдэг кодексын хэрэгжилтийн үнэлгээ байж байгаа. Тус үнэлгээгээр бид 2024 оны жилийн эцсээр топ 20 компанийн одоо эгнээнд багтаж 91.7%-ийн үнэлгээгээр 6-р байранд бичигдсэн байж байгаа. Ийм сайхан үзүүлэлтийг үзүүлсэн байж байна. Эндээс тайлагнал мэдээллийн ил тод байдал нь та бүхэн дэлгэц дээр харж байгаа бол 66.7%-тай үзүүлэлттэй гарсан байна. Үүнийг 2025 онд компани өөрийн гэсэн албан ёсны веб хуудастай болж, веб сайттай болж одоо мэдээллийн ил тод байдал тайлагналыг илүү дараагийн шатанд авчрахаар ажиллаж байна. Тогтвортой хөгжил, байгаль орчны асуудлууд бол ганц одоо манай салбар ч гэлтгүй ер нь дэлхий даяар одоо хүчтэй хөндөгдөх болсон сүүлийн жилүүдэд. Тэгэхээр тогтвортой хөгжил, байгаль орчны хүрээнд бид нар юу хийв ээ гэхээр 2024 онд бол нарийвчилсан үнэлгээнийхээ тайланг 5 жилээр батлуулсан байна. Үүнийгээ уялдуулаад химийн бодис одоо импортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрлөө бас 5 жилээр батлуулж авсан байгаа. Энэ химийн бодис ашиглах зөвшөөрөл болоод нарийвчилсан үнэлгээ гэдэг бол одоо арьс ширний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьд бол одоо гол баримт бичиг гэж ойлгож болно. Мөн байгаль орчны аудитыг хийлгэсэн байна. Тохирлын гэрчилгээг экспортын ачаа болгон дээр тохирлын гэрчилгээ авдаг байсан хуучин тогтолцоог бид халж тохирлын гэрчилгээг 3 жилийн хугацаатайгаар 2027 он хүртэл өөрсдийн экспортын гол 2 бүтээгдэхүүн болох үхэр болон ямааны вет-блү дээрээ 3 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг гардаж авсан байгаа. Мөн байгаль орчин, нөхөн сэргээлтэй холбоотой ногоон байгууламж, усны зохилтой зохистой хэрэглээ гээд ер нь энэ байгалийн шавхагдах нөөцүүдийн зөв зохистой хэрэглээг тогтвортой хөгжил талаасаа болбол манай компани дээд зэргийн ач холбогдол өгч ажиллаж байгаа. Эргэн сануулахад 2023.11.20-ны өдөр Дэлхийн арьс ширний зөвлөлийн Байгаль орчны аудитад улсаа төлөөлж амжилттай оролцож, 2 жилийн хугацаатайгаар итгэмжлэгдсэн байж байгаа.

2024 оны санхүү байдлын тайланг одоо онцлох асуудлаас та бүхэндээ танилцуулъя. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бол бид нар 591.5 сая төгрөгөөр хийсэн гүйцэтгэл нь бол 653 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр гарсан байна. Голчлох одоо ажлууд нь барилга байгууламжийн их засвар, тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлтэд голлох мөнгөн урсгалуудад зарцуулагдсан байна. 2024 онд 3.5 тэрбум төгрөгөөр химийн бодис худалдан авах төлөвлөгөө тавьж ажилласан 2.9 тэрбум төгрөгийн химийн бодисын худалдан авалтыг хийсэн байна. Та бүхний мэдэж байгаачлан химийн бодис гэдэг бол арьс шир боловсруулах үйлдвэрт өртгийн гол хувийг эзэлдэг. Химийн бодисоор одоо ихэнх боловсруулалтуудыг хийдэг учраас химийн бодис бол одоо бидний хувьд байнгын хараандаа байлгаж байх ёстой тоо байдаг. Түүхий эд худалдан авалтын төлөвлөгөөг доод

талын хүснэгтээс харж байна. Тэрбум 790 сая төгрөгөөр 100 мянган ширхэг үхрийн шир худалдаж авна аа гэж төлөвлөөд 95,437 ширхэг үхрийн ширийг 988 сая төгрөгөөр худалдаж авсан байна. 2024 оны зардалд эзлэх одоо гол томоохон зардлуудыг дараах хүснэгт дээрээс харж болно. Энд хамгийн том эзэлж байгаа нь зээл болон хүүгийн төлбөрт 5 тэрбум төгрөг. Энэ нь бол бид нар өмнө нь авч ашиглаж байсан өндөр дүнтэй зээлийг 2024 онд хаасантай холбогдуулаад одоо ийм том дүнтэй орж ирж байна. Химийн материалын худалдан авалт дараа нь байна 20%-тай 2.9 тэрбум төгрөг, за дараа нь цалин НДШ-ийн зардал бусад зардал дотор бол бид нарын энэ хэрэглээний зардлууд орж байгаа. Усны төлбөр, цахилгаан, уур гээд хэрэглээний зардлын үнийн өсөлт сүүлийн жилүүдэд ихээр нөлөөлж байна. Энэхүү нөлөөлөл нь илүү томсож байна аа үйлдвэрлэлийн өртөгт гэж үзэж байна. За энэ зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн дэлгэрэнгүй хувилбар нь та бүхний материал дээр гарын авлага дээр байгаа.

Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах

Тус компанийн 2024 оны санхүүгийн тайланд бол Сэргэлт дөл аудит ХХК маань аудит хийсэн байж байгаа. Дүгнэлтийг уншиж танилцуулъя. За бид булигаар ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүү байдлын тайлан жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам СЗХ-ноос гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна аа гэж байна. Энэ үндсэн дүгнэлт нь байна.

Аудитын дэлгэрэнгүйг дүгнэлтийг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

Гурав. 2024 онд ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулах

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Танилцуулах 3-р асуудал нь 2024 оны ногдол ашгийн тухай Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоолыг та бүхэнд танилцуулъя. Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2025.02.17-ны өдрийн 03/25 тоот Ногдол ашгийн тухай тогтоол гарсан бөгөөд уг тогтоолын 1-д “Булигаар” ХК нь 2024 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1. дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй хэмээн шийдвэр гаргасан байгаа. Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

**Дөрөв. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийг хэлэлцэн батлах**

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Булигаар ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батална. Тараах материал дээр байгаа Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр дугаар 25/5 тоот тогтоолын 1 дүгээрт Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 2 дугаарт компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитор Сэргэлт дөл аудит компаниас өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралт дахь ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Баттүшигт үүрэг болгосугай гэсэн ТУЗ-ийн тогтоол байж байгаа.

Булигаар ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт: Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

ТУЗ нь өнгөрсөн оны ээлжит хурал дээр тус компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр компанийн дүрэм, журамд заасны дагуу тогтмол хяналтыг тавин, компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос 54% өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн.

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй байснаас бодит гүйцэтгэлээр 8,628.3 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөөг 78%-ийн биелэлтэй ханган ажиллаж, өмнөх оноос мөн үеэс 19.7%-ийн өсөлтийг үзүүлжээ. Монгол Улс дахь дотоод борлуулалт 7,412.2 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 88% буюу өмнөх оны мөн үеэс 28%-ийн өсөлтийг үзүүлсэн ба гадаад борлуулалт буюу экспортын хэмжээ мөнгөн дүнгээр 1,216.1 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 46%-д хүрсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 8% буурсан байна.

Хүний нөөцийн тогтвортой бодлого барих, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор бүтэц, орон тоог тогтвортой барьж, үйлдвэрлэлийн бүтээл, гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 141,923.41 хүн/цаг ажилласан нь өмнөх оноос 4% буурсан, цалингийн зардал 4% өссөн, нэг ажилтны дундаж цалин 8% өссөн үр дүнгийн тайлангаар нотлогдож байна. Энэхүү өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь үйлдвэрлэлийн нийт гарцын өсөлт болон нэгж түүхий эд болох бод малын арьсны дундаж талбайн хэмжээ байв. 2024 онд нийт үйлдвэрлэл өмнөх оноос 20.4%-иар өсөж, бод малын арьсны дундаж талбайн хэмжээ 2023 онд 182 дм.кв байснаас 2024 онд 223 дм.кв болж даруй 22.5%-иар өссөн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагааны ашигт ажлын коэффициент өсөж буйн илэрхийлэл гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг 2024 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн бүхий л нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээл, орчин нөхцөлд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн ТУЗ-ийн зүгээс 2024 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “**Хангалттай**” гэсэн дүгнэлт өгч байна.

Тав. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: За дараагийн танилцуулах асуудал нь Булгаар ХК-ийн 2025 оны төлөвлөгөө юм. Дэлгэц дээрх хүснэгтэд 2025 оны төлөвлөгөө болон 2024 оны гүйцэтгэлтэй нь зэрэгцүүлэн харуулсан байгаа. Нийт 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тусгаж өгсөн. Үүний 930 сая төгрөг нь тоног төхөөрөмжийн худалдан авалт, тоног төхөөрөмжийн сайжралтад зарцуулагдах юм. Түрүүнд хэлсэнчлэн манай үйлдвэрт арьс шир боловсруулах процесст тоног төхөөрөмж бол маш чухал үүрэгтэй. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх гэсэн үндсэн 3 чиглэлээр болбол тоног төхөөрөмжийн шинэчлэлийг бид нар аль болох цаг алдалгүй хөрөнгө мөнгийг нь шийдэж, түргэн шуурхай хийхээр зорин ажиллаж байгаа. За дараа нь бол мэдээж барилга, дэд бүтэцтэй холбоотой их засвар байж байгаа та бүхэн мэдэж байгаа манай барилга бол хуучны барилга засаж, сайжруулах шаардлагатай. Химийн материал, түүхий эдийн худалдан авалтын 2025 оны төлөвлөгөөний хувьд 3.8 тэрбум төгрөгөөр химийн материал, 2.4 тэрбум төгрөгөөр түүхий эд худалдаж авна аа гэж төлөвлөсөн. 2025 онд нийтдээ 120 мянган ширхэг түүхий эдийг худалдаж авахаар төлөвлөж байна. Дундаж нэгж үнийг 20 мянган төгрөгт барихаар төлөвлөж байна аа. 2025 оны зардлын төлөвлөгөөнд голлох хувийг химийн материалын худалдан авалт 26.2%, үүний дараа түүхий эд 16%, бусад зардал 22%, зээл болон хүүгийн төлбөр 12.9% эзлэхээр харагдаж байна. 2025 оны зардлын төлөвлөгөөний задаргааг дэлгэрэнгүй энд харуулсан байгаа. Үүнд: Тоног төхөөрөмжийн худалдан авалт 930 сая төгрөг 6.4%, барилга байгууламжийн засвар 513 сая төгрөг, химийн бодис 3.8 тэрбум, түүхий эдийн худалдан авалт 2.4 тэрбум, цалин НДШ-ийн зардал 1 тэрбум 450 сая төгрөг, дулаан, уур, цахилгаан, ус гээд одоо ашиглалтын зардлууд байж байна. Үүнээс одоо хамгийн өндөр хувийг эзэлж байгаа нь усны төлбөрт 1.4 тэрбум төгрөгийн зардлыг бид нар тусгаж өгсөн байж байна. Усны

төлбөрийн хувьд усыг нэлээн өндөр үнэтэй худалдаж авдаг. Энэ дэлхийн жишгээс бараг 3, 4 дахин өндөр үнээр Монгол улсад усыг худалдаж авч байна. Худалдаж авсан усаа өөрсдийн цэвэрлэх байгууламжаар бид цэвэрлээд дараа дараагийн цэвэрлэх байгууламжид бохир усаа нийлүүлэн бохир усны тоолуураар бохирын төлбөр төлөгддөг мөн дараагийн шатны цэвэрлэх байгууламжид бохир ус цэвэрлэгээний төлбөрийг бас тооцон төлдөг учраас усны зардал манай үйлдвэрт нэлээн өндөр зардалд тооцогдож байна. За цааш үргэлжлүүлбэл томилолт инновацийн зардал 58 сая төгрөг, бичиг хэргийн зардал 15 сая, шатахууны зардал 49.5 сая, харилцаа холбооны зардал 6.5 сая, ариун цэвэр хог хаягдлын зардал 10 сая төгрөг, тээврийн зардал 143 сая төгрөг, зээл болон зээлийн хүүгийн төлбөрт 1.8 тэрбум төгрөг, удирдлагын зардал 35 сая, хандив тусламж 6 сая, зөвлөх үйлчилгээний зардалд 10 сая, НӨАТ-ын албан татварт 213 сая төгрөг, экспортын бүрдүүлэлт сав баглаа боодлын зардал 55 сая төгрөг, сургалт хөгжлийн зардалд 5 сая төгрөг, бусад зардалд 50 сая, аж ахуйн зардал ХАБ Эрүүл ахуйн зардалд 50 сая төгрөг, маркетинг борлуулалтын зардалд 20 сая, элэгдэл хорогдлын зардал 775 сая гээд Нийт дүнгээрээ 14.5 тэрбумын зардал гарна аа гэж 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байна. Зардлуудыг харахад зарим нэг нь татварын зардал болон бэлэн мөнгөөр гарахгүй тайлан ондоо гарахгүй зардлууд бас дотор нь байгааг та бүхэн анзаараарай. 2025 оны орлогын урьдчилсан таамаглал гэж байна. Дараагийн хүснэгтэд бид нар 120 мянган шир түүхий эд авч боловсруулаад 114 мянган ширхгийг нь эцсийн шатад боловсруулна. Нийт худалдаж авсан түүхий эдийн 5% нь гэж өөдрөгөөр бид төсөөлж байна. Түүхий эдийн худалдан авалтын бодлогыг сайжруулж илүү нягт нямбай хандаж түүхий эдийн худалдан авалтын одоо чанарыг сайжруулснаараа 5%-ийн одоо гологдол түүхий эдтэй хоцорч 114 мянган ширхэг түүхий эдийг одоо эцсийн шатад боловсруулж, дараах нэр төрлөөр нь ангилан боловсруулна. Түрүүн бас би хэлсэн ирсэн түүхий эд болгон нэг төрлийн арьс болохгүй өөр өөрийн үнэлгээтэй өөр өөр төрлийн арьс болдог байгаа. Ингээд орлогын урьдчилсан таамаглалын дагуу 13.9 тэрбум төгрөгийн орлого олно гэж төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Анхболд: Өнгөрсөн жилийн дундаж талбайг 223 дм.кв тэгсэн үү?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Тийм, 223.6 дм.кв

Хувьцаа эзэмшигч Б.Анхболд: Өнгөрсөн жилийн бодит худалдан авалт 988 сая төгрөгөөр 95 мянга арьс худалдан авсан. Дундаж нэгж түүхий эдийг 10,353 төгрөгөөр авсан гэж байна. Энэ жил яагаад арьсыг 20 мянгаар үнэлээд байгаа юм. Арьсны үнэлгээг нэмэгдүүлсэн шалтгаан юм бол?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Энд 2 шалтгаан байгаа. эхний шалтгаан нь компанийн түүхий эдийн бодлогод чанар өндөртэй түүхий эдүүдийг өндөр үнээр худалдаж авах бодлого бариад явж байна. 2 дугаарт нь 2025 онд манай улсад мэдээж энэ үнийн өсөлт, инфляц бас нөлөөлнө. Тэр нөлөөлөл бас орж ирнэ гэсэн. Энэ 2 шалтгааны улмаас ерөнхийдөө 20 мянган төгрөг дээр тавьсан байж байгаа. Гүйцэтгэх захирал миний зүгээс ер нь хараад байгаа нэг юм нь түүхий эд одоо манай үйлдвэр лүү орж байгаа гол орц. Түүхий эд өөрөө маш чанартай байх ёстой түүхий эд маань ингээд үнэ нь унаад байх тусам түүхий эдийн чанар муудаад байна. 2-т түүхий эд хангалттай хэмжээнд хүссэн хэмжээнд цагтаа цуглаж чадахгүй байна. За энэ 2 асуудлууд ерөнхийдөө манай салбарт бол тулгамдаад байна аа. За манай үйлдвэрийн хувьд бол салбарын ууган үйлдвэр түүчээлэгч үйлдвэрийн хувьд бол энэ түүхий эдийн үнийг боломжит хэмжээнд нь өсгөх талаас нь, чанарыг нь сайжруулах талаас нь зорилгоо болгоод ажиллаж байна.

Ерөнхийдөө Эмээлт зах дээр, түүхий эдийн төвлөрсөн зах дээр яг өнөөдрийн байдлаар түүхий эд 10, 11 мянган төгрөгийн үнэтэй байж байна аа. За энэ 10, 11 мянган төгрөгөөр авсан түүхий эд рүү одоо жишээ болгоод хэлэхэд бараг нэг хүн тонгойгоод тэр түүхий эдийг өргөхөд л түүхий эдийнхээ зардлаас үнээс өндөр дүнтэй хөдөлмөрийн зардал гарчхаад байна. Тэгэхээр бид юу гэж үзэж байна вэ гэхлээр тонгойж байгаа энэ хөдөлмөрийн зардал нь түүхий эдээсээ үнэтэй юм бол түүхий эд нь анхнаасаа л чанартай байх ёстой юм байна. Чанартай түүхий эдээр чанартай бүтээгдэхүүн хийе гэж зорьж байна.

Хувьцаа эзэмшигч: 10, 11 мянган төгрөг дотор тээврийн зардал орсон байдаг уу. Хоёрт махны компаниуд одоо өөрсдөө зөндөө хөгжүүлэлт энэ тэр хийдэг болсон. Тэгээд өөрсдийнхөө аль болох тэр зээлийн материал дээр л бид нар өөрсдөө мэдээгүй байхад бол хариуцдаг компаниуд надад өргөн тушаана гээд л бичдэг л юм байна л даа. Надаас асуугаад би энийг чинь мэдэхгүй байна. Тэгэхээр махны компани гэдэг хүн хэдэн төгрөгөөр бид нарт анх зардаг юм юу гэж зээл авч байсан юм бид нар. Тэгэхээр энэ жил 120 мянгаас бүгдээрээ 20 мянгаар авна гэж байхгүй байх. Дундаж нь 20 мянгатай бас л жигнэсэн дундаж өндөр байгаа байхгүй юу. Юу үзээд тийм өндрөөр тавьчихна вэ?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Үнийн өсөлт мэдээж нөлөөлнө. Түүхий эд энэ байдлаараа бага үнэтэй байгаад байвал хангалттай сайн цуглаж чадахгүй. Бид нарын хувьд бол цаг хугацаатай уралдаж ажиллаж байна. Яг өвлийн энэ оргил хүйтэн саруудад бол их хэмжээний нөөцийг бэлтгэж одоо хавар, намрын энэ түүхий эдийн чанар муутай саруудад үйлдвэрлэлээ тогтвортой байлгах журмаар өвлийн улиралд бол их хэмжээний түүхий эдийг бэлдэх шаардлагатай байна аа. Одоо өнгөрсөн жилүүдийн туршлагаас харахад болбол өвлийн улиралд энэ түүхий эдүүд бол хангалттай бидний хүссэн хэмжээнд цуглаж чадахгүй байна. Манай одоо үхрийн шир өөрөө 1 ширний жин 20кг өөрийнх нь үнэ нь 10 мянган төгрөг хажууд нь нэг ямааны арьс байж байна. Өөрийнх нь жин нь 4кг арьсных нь өртөг ноолууртайгаа 50, 60 мянга болчихоор хөдөө орон нутгаас Улаанбаатарт цуглахдаа эхэлж үр ашигтай тээврүүд нь эхэлж ирээд үхрийн шир хамгийн сүүлд нь цуглаад байна. Энэ одоо бас бидний тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөөллийг үзүүлээд байна. Махны үйлдвэртэй холбоотой асуулт асуулаа. Махны үйлдвэртэй бол одоо аль болох хамтарч ажиллах, махны үйлдвэрүүдээс чанартай түүхий эдийг бэлтгэх тал дээр бид нар байнгын ажиллаж байна. Энэ оны хувьд болон 2024 оны сүүлийн саруудад бас хэрэгжээд эхэлсэн байж байгаа Налайхад байж байгаа 2 махны үйлдвэр байна. Траст трейд тэгээд цаана Хэнтий аймгийн Чандманийн талд байрлах Мэтагро гэж сүүлд манай улсад хийгдсэн томоохон махны чиглэлийн хөрөнгө оруулалт байж байгаа. Мэтаграгийн үйлдвэрээс бид нар түүхий эд аль болох чанартай бэлдүүлж өндөр үнээр авсан тохиолдол байна. Гэхдээ энд ганцхан саад бэрхшээл нь юу вэ гэхлээр махны үйлдвэрүүдээс бэлтгэгдэж байгаа түүхий эд буюу үхрийн шир бид нарын үйлдвэрлэж байгаа тоо хэмжээтэй уялдаж өгөхгүй байгаа. Манай улсын хамгийн сүүлд баригдсан тэр жишээ дурдахад Мэтагро гээд махны үйлдвэр байж байна. Өдөрт 40 ширхэг бодын арьс гаргаж байна. Бид бол энд өдөрт 800, 900 ширхэг бодын арьсны тухай яриад байдаг. Манай махны үйлдвэр болохоороо 40 ширхэг, 20 ширхгийн тухай яриад байхаар энэ дундын алслагдмал байдал тээвэр логистикийн хүндрэлүүдээс шалтгаалаад махны үйлдвэрүүдийг одоо байнга хүлээж, зөвхөн махны үйлдвэрийн арьсаар хийх одоо боломжгүй юм байна. Гэхдээ аль болох энэ худалдан авалтын түүхий эдийн худалдан

авалтынхаа багцдаа махны үйлдвэрүүдээс авч байгаа түүхий эдийг нэмэгдүүлэх гэсэн хараатайгаар ажиллаж байгаа. Үнийн хувьд бол түрүү жил хамгийн өндөр үнээр одоо Метагро компаниас 35 мянган төгрөгөөр хүртэл бас шир авч үзсэн тэгэхдээ 20 ширхэг 30 ширхэг ширний тухай л ярьж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Анхболд: Арьс нь том байж чадаж байна уу?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Том сайн 28 кг, 32 кг-тай арьснууд ирдэг. Гэхдээ түрүүн хэлсэнчлэн тоо нь бол 10, 20 ширхэг

Хувьцаа эзэмшигч: Тэгээд нөгөө нэг арьсыг нь нөгөө машинаар татаж бэлтгэдэг үү?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Тийм яг зөв. Тэр бол үнэхээр сайхан арьснууд ирдэг. Яг машинаараа ингэж махны үйлдвэрт татаж аваад бэлтгээд ирдэг.

Хувьцаа эзэмшигч Б.Анхболд: Тэгээд 35 мянгын арьсыг боловсруулаад борлуулах, 10 мянгын арьсыг боловсруулаад борлуулахаас ашгийн түвшин нь ер нь илүү байж чадаж байгаа юу?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Илүү байж чадаж байгаа. 35 мянгын шир бол үнэхээр сайн ширээр. 1-рт талбай нь өсөөд явчихна гэмтэл нь байхгүй бол чанар нь өсөөд зэрэг нь дээшлээд явчихна. Одоо яг адилхан арьсыг боловсруулаад тавихад түрүүн хэлсэн дундаж талбай 220 дм.кв гэж гарч байсан тоон дээр 220дм.кв гэдгээс зэргийн зөрөө дээрээс л тооцоход 1 дүгээр зэрэг 3 дугаар зэрэг хоёрын хооронд 70, 80 төгрөг зарим артикль дээр 100 төгрөгийн зөрөө байгаа юм. Тэгэхээр 200-г 100-гаар үржүүлэхээр 20 мянган төгрөгийн зөрөө гарч байна гэсэн үг. Энд яг адилхан материал орж байна. Яг адилхан хөдөлмөр шингэж байна. Хийж хийж байгаад гаргаад ирэхээр зэргээрээ ингээд салаад явчихдаг гэсэн үг. Тэгэхээр түүхий эд бол анхнаасаа чанартай байвал илүү үр ашигтай ажиллаж болох юм байна аа гэсэн алсын хараатайгаар ажиллаж байгаа гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч С.Амаржаргал: Гүйцэтгэх захирлаас нь 3 асуулт асуух гэсэн үг. 1 дүгээрт Ашигт ажиллагааны талаар асуумаар байна л даа. Орлого зарлага 2 чинь ер нь тэнцээд ашгийг нь харж байвал бага хувьтай орно шүү дээ. Тэгэхээр ер нь хэдэн оноос энэ ашигт ажиллагаа руугаа орно гэж үзэж байгаа вэ? 2 дугаарт нь болохоор 2025 онд 14 тэрбум төгрөгийн орлоготой ажиллах юм байна шүү дээ гэж төлөвлөсөн байна л даа. Тэгэхээр одоо 1 дүгээр улирал өнгөрчихлөө 1 дүгээр улирлын байдлаар хэдэн хувийн гүйцэтгэлтэй байна гээд яах вэ орлогын хувьд шүү дээ. 3 дугаарт нь хувьцаа эзэмшигч хүмүүс юу хүсдэг вэ гэхээр ногдол ашиг гэж юм компаниудаас хүсдэг тэгэхээр одоо ногдол ашгийн бодлого гэж заасан юм байна уу? За энэ жил бол 2025 оны ингээд орлого зарлагыг чинь харахад бол ногдол ашиг бас тараахааргүй л юм шиг л юм харагдаж л байна л даа. Тэгэхээр ер нь хэдэн оноос энэ ногдол ашгийнхаа бодлогыг одоо яг хувьчилж буцаагаад шийдсэн ч юм уу эсвэл хэдэн оноос ноогдол ашиг тараана аа гэсэн юм бол?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: 1 дүгээр асуулт 3 дугаар асуулт бол хоорондоо ерөнхийдөө уялдаатай байна гэж ойлгож байна. Хэдэн оноос эхэлж энэ компани үр ашигтай ажиллаж үр шимээ өгөх вэ? Хувьцаа эзэмшигчдэдээ ноогдол ашиг хуваарилах вэ? За энэ асуултад одоо хариулахад хамгийн 1 дүгээрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Цагаан алт гээд том хөтөлбөр улс орон даяар хэрэгжээд явж байна. Өмнөх ЗГ-ын бодлогуудаас ялгаатай нь 3 салбар онилж байгаа. Энэ нь юу вэ гэхлээр арьс шир ноос ноолуур энэ хөтөлбөрийн хүрээнд болбол манай салбар ойрын 2-оос 4 жилийн дотор салбарын хэмжээнд ярьж байгаа юм шүү 2-оос 4 жилийн дотор эцсийн бүтээгдэхүүнийхээ эцсийн шатанд боловсруулж байгаа арьсныхаа тоо хэмжээг 30%-аас

50% болгоод өсгөнө өө гээд салбараараа зорилт тавиад ажиллаж байгаа энэ салбар дотор түүчээлэгч одоо манай үйлдвэрийн хувьд энэ тоог эрхэмлээд баримтлаад ажиллана аа гэсэн үг. Тэгэхээр салбар сэргээд эхлэхлээр аяндаа бид нарын ашигт ажиллагаа сайжраад ирнэ гэж би харж байна. 2 дугаарт нь энэ хөтөлбөрийн хүрээнд түүхий эдийн чанарыг сайжруулах одоо том том ажлууд бас хийгдээд явна. Таны хэлж байгаа үнэн иймэрхүү байдалд одоо ашигт ажиллагаа төдийлөн сайнгүй ажиллахад хүргэж байгаа үндсэн одоо 2 шалтгаан байгаа. Эхнийх нь болбол түүхий эдийн чанар байна 2 дугаарт нь бол манай энэ үйлдвэрийн одоо бизнес модель гэж ярих вэ. Энэ үйлдвэр маань одоо жилд 350 мянган шир боловсруулах хүчин чадалтайгаар 1976 онд одоогийн энэ дэд бүтэц зураг төслөөр энэ үйлдвэр баригдсан 350 мянган шириг 2 ээлжээр 400 хүн энэ үйлдвэрт ажиллаж тухайн үед боловсруулдаг байсан. Одоо бид нар жилдээ 120 мянган шир боловсруулъя. 70 хүнтэйгээр манай одоо үйлдвэр өнөөдөр үйл ажиллагаа явж байна. Тэгэхээр энэ бизнес модель ингээд хоорондоо бас зөрөлдөөд байна. Би үүнтэй юуг уяж тайлбарлах гээд байна гэхлээр салбар маань эхлээд хөгжих ёстой. Та түрүүн миний слайд дээрээс бас харсан байх. Гадаад зах зээл төдийлөн сайнгүй байна. Тэгэхээр дотоод зах зээлээ цөмөөрөө барьж авах ёстой. Импортыг орлох арьсыг хийх ёстой, үнээр өрсөлдөх чанараар өрсөлдөх шаардлагатай. Энэ бол гол алсын хараа гэж ойлгож болно.

Хувьцаа эзэмшигч С.Амаржаргал: Энэ салбарын одоо нийт борлуулалт байна шүү дээ. Арьс ширэн бүтээгдэхүүний танайх компани хэдэн хувийг хийдэг вэ?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Арьс ширэн бүтээгдэхүүн биш арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх эцсийн шатанд боловсруулсан арьс зарагдаж байгаа. Энэ арьсны 50-аас дээш хувийг нь манай үйлдвэр хангаж байна. Монголдоо үлдсэн 20%-ийг нь импортын арьс хангаж байна. 30%-ийг нь бусад үйлдвэрүүд хангаж байна гэж хараад байна.

Хувьцаа эзэмшигч Б.Анхболд: Бид ирэх жилийн энэ ашгийг шууд ингээд орлого, зарлага өсөж байна гэж харж болохгүй байх аа. Нөгөө талаасаа яагаад вэ гэхээр энэ дээр сая тэрбум 600 тэрбум төгрөг хөрөнгө оруулалт, банкны зээл цагаан алтаас авч байгаа зээл чинь өртөг нь нийлээд энэ 3 тэрбум төгрөгийн зардал бол цаашдаа хөнгөрөөд өгөөч. Энэ тэрбум 600 сая төгрөг хэдийгээр нэг удаадаа гаргаж байгаа мөнгөн зардал боловч үйлдвэрлэлийн өртөг суух тал дээр бол хамаагүй багасгаж байдаг. Тэгэхээр компанийн ашгийн түвшнээр эцсийн баланс дээр болбол ирэх жил гайгүй болох байх гэж би ойлголоо шүү дээ. Зөв үү?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Тийм тийм

Хувьцаа эзэмшигч Б.Баянжаргал: Үндсэн төлөлтөө зардалдаа бол одоо тавих байх гэж бодлоо?

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг: Тэгж байгаа.

Зургаа. ТУЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг танилцуулах

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн. Сүүлийн 3 жил хараат бус гишүүнээр ажиллаж байгаа. Өнгөрсөн жилийн ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өгөхөд ТУЗ нь өнгөрсөн жил ХЭХ-аар сонгогдоод тэрнээс хойш жилийн хугацаанд нийтдээ 9 удаагийн хуралдаанаар 14 тогтоол, 9 тэмдэглэлээр шийдвэр гарган

хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. Хурлыг ихэнх нь танхимаар, зарим хурал нь бол цахим болон эчнээ хэлбэрээр явагдсан. Эчнээ хэлбэрээр явагдсан хурал нь голдуу эрх олгох хурлуудыг эчнээ болон цахимаар хийгээд явсан. Бусад хуралдаанууд бол дандаа танхимын хуралдаан хийж үйл ажиллагаа явуулсан. Ингээд хуралдсан тоо, тогтоол, гаргасан чиглэл, ирцийн тухай мэдээлэл нь та бүхэнд таарагдсан ХЭ-ийн хурлын тарааж өгөх материал дээр хуудас 25, 26 дугаар хуудсанд танилцуулга байж байна. Та бүхэн тоон мэдээллийг дэлгэрэнгүй харж болно. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд зардлыг 2024 онд 16.6 сая төгрөгийн зардал гаргахаар 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар төсөв баталсан. Гүйцэтгэл нь 14.1 сая төгрөг буюу 84.8%-ийн зарцуулалтаар гүйцэтгэл хийгдсэн. Энд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, ХЭХ-ын зардал буюу ХЭХ хуралдуулах хурлын зар мэдээг хүргэх, түгээх, зохион байгуулахтай холбоотой зардал, бусад зардал нь үйлчилгээний хураамж. Үйлчилгээний хураамж гэдэгт юу байдаг вэ гэхээр Монголын хөрөнгийн бирж гишүүнчлэлтэй ХК-ийн бүртгэлийн хураамж, Үнэт цаасны төвлөрсөн халамжийн төвд Булигаар ХК-ийн хувьцааг хадгалж гэрээгээр хадгалдаг. Тэрний хадгалалтын жилийн хураамж, бусад үйлчилгээний хураамжууд орсон байгаа. Зардлыг төлөвлөгөө болон гүйцэтгэлээрээ энэ хуудсанд слайд дээр байж байна. Та бүхэнд тарааж өгсөн хурлын материал дээр бас байгаа.

2 дахь асуудал нь бол өнөөдөр хэлэлцэх асуудал. 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг энэ хүснэгтээр та бүхэнд хувьцаа эзэмшигчид танилцуулж байгаа юм. 1 дүгээрт эхний асуудал бол ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын асуудал. Дараагийнх нь болохоор хуралдааныг зохион байгуулах явцад гарч байгаа бичиг хэргийн зардал болон хураамжийн зардлууд бүгд орсон байгаа. Энэ дээр: Хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн хураамж бол жилд нэг удаа 500 мянган төгрөг. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хувьцаа хадгалуулсан хадгаламжийн хөлс бол жилийн 500 мянган төгрөг, Ногдол ашиг тараах тохиолдолд ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулж тараахад 100 мянган төгрөгийн хураамж өгдөг. Санхүүгийн тайланд аудит хийх ажлын хөлсний хүрээнд 6 сая төгрөг, Тархалтын мэдээ. Өөрөөр хэлбэл Булигаар ХК-ийн ХЭ-ийн хурал зохион байгуулахад бүртгэл бүртгэх өдөр гэж тасалбар олгодог. Тэр тасалбар болгож байгаа өдрөөрх хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээ гээд аль ҮЦК дээр хэн хэн гэдэг хүн хэчнээн хувьцаа эзэмшиж байгаа вэ гэдэг тархалтын мэдээ нэгдсэн мэдээг Үнэт цаасны төвлөрсөн халамжийн төвөөс авдаг. Тэрний мэдээ авахад зарцуулах мөнгө 121 мянга төгрөг. Хурлын зар мэдээ түгээх гэдэг нь ХМХ болон ҮЦК хөрөнгийн биржийн сайтаар дамжуулж мэдээлэхэд бол гардаг зардал. Тэрэнд давтамжтайгаар өгдөг учраас 1 нэгжийнх нь үнэ 200 мянга. Давтамжтайгаар зарлах гэдгээр нь тооцож байна. Хувьцаа эзэмшигчдэд өгөх гарын бэлэг гэдгээр 600 мянган төгрөг гэсэн ийм зардал гаргаад 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг 18.2 сая төгрөгөөр төсөвтэй байхаар ХЭ-ийн хуралд оруулж байна. Та бүхэнд баярлалаа.

Долоо. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Хурлын дарга Б.Баттүшиг: Гуравдугаар хэлэлцэх асуудал бол Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдээ түрүү жилийн

сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ үргэлжлүүлэн сунгаад ажиллуулъя гээд санал оруулж байгаа юмаа. Тарааж өгсөн материалд нэр дэвшигчдийн анкет танилцуулгыг оруулсан байгаа. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрсийг танилцуулахад:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид

1. Төмөрбаатар овогтой Болд
2. Чулуунбаатар овогтой Нямдорж
3. Жадамба овогтой Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчид

4. Батчулуун овогтой Анхболд
5. Батчулуун овогтой Баянжаргал
6. Анхболд овогтой Энхмэнд
7. Довжид овогтой Гансүх
8. Бямбабаяр овогтой Баттүшиг
9. Цэрэндагва овогтой Мөнхлхагва эдгээр хүмүүс нэр дэвшиж байна.

Эдгээр нэр дэвшигчдээс асуух зүйл байна уу.

Та бүхний материал дээр байгаа хурлаас гарах түрүүн би хурлын эхэнд хэлсэн 3 асуудлыг бид нар хэлэлцэж байгаа. 1 дүгээрт 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, 2 дугаар тогтоолд ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай, 3 дугаар тогтоолд ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай байгаа.

Хувьцаа эзэмшигч: Хараат бус гишүүдээ яаж сонгон шалгаруулж байна аа?

Хурлын дарга Б.Баттүшиг: Хараат бус гишүүдээ анх сонгон шалгаруулахдаа бол олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлал өгч сонгосон.

Хувьцаа эзэмшигч: Хараат бус байж чадаж байна уу?

Хурлын дарга Б.Баттүшиг: Хараат бус байж чадна. Учир нь компанийн тухай хуулийн 79.1 дэх заалтуудыг хангаж байгаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: ХЭ-ийн хурлын зар мэдээг компанийн тухай хуулиар 40-өөс дээш хоногийн өмнө ХЭ-ийн хурлыг зараар түгээдэг. Тэгэхээр энэ өдрөөсөө эхлэн нэр дэвших эрх нь нээлттэй байдаг. Дэвшиж байгаа хүмүүс орж ирэхгүй байгаа болохоор л нэр дэвшсэн материалуудыг дэвшүүлээд оруулчихаад байх юм байна. Хараат бус дээр яг 3 хүн заавал орох учир ахиад 4, 5, 6 дахь хүний материал ирээгүй л гэдэг асуудал байгаа.

Хувьцаа эзэмшигч: 3 асуулт байна. 1 дүгээрт Нийслэлээс энэ арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх асуудал яригдаад байгаа? Олон жил яригдсан. Энэ жил нэлээн эрчтэй яригдаж байх шиг байна. Энэ ажлыг явц нь ямар байгаа юм бол? Булигаарын оролцоо ямар байгаа вэ? 2 дугаарт Евроазийн эдийн засгийн холбооны хэлэлцээр хийх гээд байгаа шүү дээ э тэр дээр яг компани дээр ямар боломж гарч ирж байгаа вэ? Ер нь тийм боломж гарах уу 3 дугаарт хараат бус гишүүдийн цалин хөлс бол арай бага юм аа. Ядаж энэ хуулийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хангах нь зүйтэй байх.

Хурлын дарга Б.Баттүшиг: Гурав дахийг асуулт гэхээсээ илүү санал гэж ойлгож байна. Саналыг хүлээгээд авлаа. 1 дүгээр асуултад хариулъя. Эмээлт эко аж үйлдвэрийн парк гээд нийслэл дээрээс одоо хэрэгжүүлээд байгаа төсөл байгаа. Миний олж сонссоноор болбол нийслэлийн 2025 онд жагсаасан 22 мега төслийн 18 дугаарт нь бичигдээд явж

байна. За энэ Эмээлт Эко аж үйлдвэрийн паркийн удирдлагуудтай ер нь энэ дэд бүтцийнх нь шийдэл нь ямар шатандаа явж байна? Цаашдаа энийг яаж төлөвлөх вэ? Энэ талаар мэргэжлийн байгууллагынхаа зүгээс, компаниараа ч тэр мэргэжлийн холбоогоороо ч дамжуулаад байнгын харилцаа холбоотой ажиллаж байна. Миний олж сонссон мэдээллээр, энэ онд 30 тэрбум төгрөгийн төсөв суулгаж өгсөн байна. Эмээлт Эко аж үйлдвэрийн парк дээр энэ 30 тэрбумын төсвөөрөө хамгийн эхний шатны дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх одоо ажлууд нь эхэлж байна гэж сүүлийн үеийн мэдээлэлтэй байж байгаа. Евроазийн эдийн засгийн холбоотой манай ЗГ-ын гэрээ зурах гээд байгаа. Манай хөнгөн аж үйлдвэрийн салбарынхан бол төдийлөн сайнаар авч харахгүй л байна тэр гэрээг бидний хувьд ч гэсэн ялгаагүй. Одоо тэр гэрээтэй гэрээгүй Орос арьс импортын арьснууд одоо бидний зах зээлд одоо алхам тутамдаа л ерөнхийдөө хүч түрж байна. Тэгэхээр одоо бид нар илүү сайжрах шаардлагатай. Дараагийн шатад бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа.

Хувьцаа эзэмшигч: Экспорт дээр ямар ч юу байхгүй юу?

Хурлын дарга Б.Баттүшиг: Салбарын хүрээнд арьсны тухайд экспорт дээр яг Евроазийн орон дундаа бол төдийлөн экспортын боломжууд бол олж харахгүй байгаа би хувьдаа. Би өөрөө Турк улсад мэргэжил эзэмшсэн болохоор энэ Евроазийн орнууд, Монголын газрын зургаас баруун тийшээ хөөвөл Турк хүртэл судалсан. Экспортын тал дээр төдийлөн өндөр хүлээлт байхгүй нөгөө талаасаа импорт нь манай салбарт сөргөөр нөлөөлж болзошгүй гэж харж байна. За энэ бол миний хувь хүний өнцөг шүү.

Хувьцаа эзэмшигч: Химийн бодис, будгаа хаанаас авдаг вэ?

Хурлын дарга Б.Баттүшиг: Химийн бодис, будгийн хувьд хамгийн чанартайг нь Испани, Герман улсаас, наашлаад Турк улсаас авч байна. БНХАУ-аас авч байна. Арьс ширэнд ашиглаж байгаа химийн бодисыг дотор нь салгавал, хоолоор ярвал, хамгийн чанартай нарийн ногоо, амтлагчийг нь европоос ирж байгаа, давс, төмс зэргийг БНХАУ-аас авч байгаа гэж ойлгож болно.

Хувьцаа эзэмшигч: Орлогын тайлан дээр түрээсийн орлого гэж байсан тодруулж өгнө үү?

Хурлын дарга Б.Баттүшиг: Талбай түрээс биш л дээ. Мобиком, Юнител үрэн телефоны операторын дахин дамжуулах антен байдаг юм. Тэр антенуудад операторууд нь бага хэмжээний төлбөр төлдөг юм.

Хувьцаа эзэмшигч: За жижиг хувьцаа эзэмшигчид юу гэж үзээд байгаа вэ гэхээр жишээлбэл би ингээд танай компанийг үзээд сонирхоод за хурал нь ямар болдог юм байна? Ер нь үйл ажиллагаа нь ямар байна? Цаашдаа бизнес төлөвлөгөө хэр байна? Энэ дээр хувьцаа худалдаж авах уу болох уу гэдэгт одоо би ингээд хуралд суугаад тодорхой хэмжээний итгэл үнэмшилтэй болчихлоо. Дараагийнхаа хүмүүст санал болгохоор л болж байна л даа. Одоо ийм 3 дугаар ангиллын компанийн цаашдын ашигт ажиллагаа нэмэх боломжтой юм байна аа. Гээд өөрөө нүдээрээ хараад ингээд үзчихсэн учраас тэгэхээр жижиг хувьцаа эзэмшигчдээ үйлдвэр дээртэй танилцуулаад арьс шир ингэж боловсруулдаг гээд тийм үйл ажиллагаа явуулах боломжтой юу? Тэгээд нүдээрээ харьж үзсэн юм. Бас нэг өөр тээ? Тэгвэл ингээд дараа дараагийн бас хувьцаа эзэмшигчид санал болгох нөхцөл байдал байна л даа?

ТУЗ-ийн гишүүн Б.Анхболд: Ер нь бол тиймээ болно. Одоохондоо хувьцаа төвлөрөлтэй байгаа. Бид нар бас хувьцаа нэмж гаргах, зах зээл дээр халаасны хувьцаа гаргаж, энэ

үнэтэй банкны зээл авахгүйгээр ашиглах боломжууд ашиглах хэрэгтэй. Энэ дашрамд Баттүшиг захирлыг танилцуулчихъя. 2019 онд бид бүхэн энэ компанийн хяналтын багцыг аваад ажиллахад анх орж ирж, хамтран ажилласан залуу байгаа. Турк улсын Измерит арьс ширний салбараар сургууль төгссөн Монгол улсад 4-өөс 6 л технологич нар байдаг. Тэрийн сүүлд төгсөж ирээд ажиллаж байгаад манай орж ирээд технологичоор ажиллаж байгаа түрүү жилээс удирдлагаар залуу хүмүүст, хараат бус байдлаар шилжүүлэн олгосон байгаа. Тэгээд энэ залуучууд маань багаараа энэ үйлдвэрийг сайн ажиллуулж байгаа гэж үзэж байна. Түрүүчийн асуудалд хариулахад нүүх асар их зардал гарах байгаа, 20-30 тэрбумын төгрөгийн зардал гарахаар байгаа. Түрүү Баттүшиг захирлын ярьсанчлан нэг ёсондоо нэг их том угаалгын машин дотор бид нар нэг жижигхэн цамц хийгээд угаагаад байгаа юм шиг л яваад байгаа байхгүй юу. Үйлдвэрийн барилга, ер нь зардлын хувьд энэ том ажлыг төлөвлөхийн тулд энд боловсруулж байгаа ажлыг дараагийн секц рүү тийш нь аваадахъя гэдэг. Тэгэхэд чинь одоо сүүлийн үеийн яг энэ хэмжээгээрээ төлөвлөгдсөн бол яг жинхэнэ байж байгаа шүү дээ. Ингээд хүн хүчний зардал ч өндөртэй, цаг хугацаа бүтээмжийн зардал ч өндөртэй байгаа тул нүүж очиход компанийн зүгээс бол 100% дэмжсэн хамгийн түрүүнд нүүчих ч юм сан гэсэн бодолтой байгаа. Тэгэхгүй бол бид нар энэ 20-30 мянган м.кв-аас гарахгүй бол их хамааралгүй ийм байдаг газар байхгүй. Маш их оновчтой сүүлийн үеийн шийдэлтэйгээр энэ үйлдвэр явагдана. Тэр нь нэмж хувьцаа гаргавал хөрөнгийг босгоно гэсэн хүлээлттэй байгаа.

Хурлын дарга Б.Баттүшиг: Саналын хуудас тараагдсан байгаа. Санал хураалт явагдах гэж байна.

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: Саналын хуудас дээр хэлэлцэх 1, 2 дахь асуудлаар санал өгөхдөө ердийн журмаар нэмэх тэмдэг болон зөвлөх тэмдэглэгээ хийж саналаа өгнө. Дараагийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлын хүрээнд 9 гишүүнийг кумулятив аргаар сонгогдох байгаа, 9 гишүүний тоог таны эзэмшиж буй хувьцааны тоогоор үржүүлээд 3 дахь хэлэлцэх асуудалд өгөх саналын нийт тоо гарч ирнэ. Кумулятив аргаар яаж санал өгөх талаар саналын хуудасны арын хуудас дээрх 6 дугаарт тайлбарласан байгаа. Саналын эрхтэй нийт тоог аль нэг гишүүдэд хувааж өгөх маягаар эсвэл нэг гишүүнд өөрийн саналын өгөх боломжтой байгаа.

Хурлын дарга Б.Баттүшиг: Хурлын завсарлагааны цагаар үйлдвэртэй танилцуулах болно.

САНАЛ ХУРААЛТ:

Санал хураалт 5 минут үргэлжлэв. 10 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Г.Анужин: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн боллоо. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Санал хураалтын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Булигаар ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Санал хураалтаар 88.13 хувийн саналын эрхтэй 352,713,190 ширхэг хувьцааны 10 ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

Хоёр. Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 99.99% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,700,190	99.99631%	13,000	0.00369%	0	0%

Гурав. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 99.99% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,700,090	99.99629%	13,100	0.00371%	0	0%

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг кумулятив аргаар 352,713,190 ширхэг хувьцаатай 10 хувьцаа эзэмшигч саналаар дараах нэр дэвшигчид нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд сонгогдсоныг мэдэгдсүгэй.

Хараат бус гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Төмөрбаатарын Болд	88.11%	352,629,300
2	Чулуунбаатарын Нямдорж	88.11%	352,638,300
3	Жадамбын Эрдэнэбат	88.13%	352,699,300

Ердийн гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Батчулууны Анхболд	88.11%	352,629,000
2	Анхболдын Энхмэнд	88.13%	352,699,000
3	Батчулууны Баянжаргал	88.11%	352,629,000
4	Довжидын Гансүх	88.14%	352,746,000
5	Бямбабаярын Баттүшиг	88.11%	352,629,000
6	Цэрэндагвын Мөнхлхагва	88.11%	352,629,000

Тооллогын комиссын дарга Г.Анужин

Тооллогын комиссын гишүүд Д.Энхзул, Ю.Дүгэрмаа

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Баттүшиг танилцуулав.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 25/01 ЦУХ тоот тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.

Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүнг харгалзаж олгож байхыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1, 7.18, 7.19 дэх заалт, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнээр улируулан сонгосугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Төмөрбаатарын Болд
Чулуунбаатарын Нямдорж
Жадамбын Эрдэнэбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд
Анхболдын Энхмэнд
Батчулууны Баянжаргал
Довжидын Гансүх
Бямбабаярын Баттүшиг
Цэрэндагвын Мөнхлхагва

- Хоёр. Компанийн дүрмийн 7.19-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
- Гурав. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм журмуудыг мөрдөж ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Хурлын дарга Б.Баттүшиг: Булигаар ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурал 14 цаг 35 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



Б.БАТТҮШИГ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн.

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧИГ:

Г.ЦЭЭПИЛЖИД